

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код.79.040

Түлшний мод. Техникийн шаардлага	MNS 5413 : 2011 MNS 5413:2004-ийн оронд
Firewood. Technical requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандарт нь түлшний зориулалтаар бэлтгэж хэрэглэх модны төрөл, түүнд тавих техникийн шаардлагыг тогтоож, түлээний модыг бэлтгэхэд зөвшөөрөл олгох, хэрэглээ болон тээвэрлэлтэд хяналт тавихад оршино.

2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь түлшний зориулалтаар ашиглагдах шилмүүст ба навчит төрлийн модон түлээг бэлтгэх, хүлээн авах, хянаж шалгах, тээвэрлэхэд хамаарна.

3 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд энэ стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 8966:2002, Мод бэлтгэх аж үйлдвэр - Бүтээгдэхүүн - Нэр томъёо ба тодорхойлолт,
- MNS 2379:2010, Бөөрөнхий модон материалын эзэлхүүний хүрд,
- MNS 126:2010, Шилмүүст төрлийн бөөрөнхий модон материал,
- MNS 170:2010, Навчит төрлийн бөөрөнхий модон материал,
- ГОСТ 3243:88, Түлээ. Техникийн шаардлага.

4 Нэр, томъёо тодорхойлолт

Энэ стандартад хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

4.1

Түлшний мод

өөрийн хэмжээ ба шинж чанараараа хэрэгцээний модны шаардлагад тохирохгүй, зөвхөн түлшинд ашиглаж болох өнгөний хувиралт, өмх, яр, гүн ан цавтай, чанарын хувьд бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжгүй, бөөрөнхий буюу цуулж хагалсан, түлшний зориулалттай мод, модлогийг;

5 Ангилал

Түлшний зориулалтаар ашиглах модыг дулаан ялгаруулах чадвараас нь хамааруулан модлогийн төрлөөр гурван бүлэгт хуваана:

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны албан хэрэгцээнд олгов.
Монгол улсын стандарт мөн болно. 2011-10-02
Стандартыг сүлжээгээр болон хэвлэн олшруулахыг хориглоно.

MNS 5413 : 2011

- 1 – хус, шинэс, хайлаас;
- 2 – нарс;
- 3 – гацуур, хуш, жодоо, улиас, улиангар, бургас;

Түлшний модыг төрлөөс нь хамааруулан дараах байдлаар ангилна:

- а. нэг төрлийн;
- б. холимог төрлийн;

Нэг төрлийн түлшний модонд нэг төрлийн модноос дангаар бэлтгэснийг, холимог төрөлд бусад өөр төрлийн модноос хольж бэлтгэснийг тооцно.

6 Техникийн шаардлага

6.1 Түлшний модонд хүснэгтэд заасан дараах хэмжээг мөрдөнө.

Д/д	Түлшний модыг бэлтгэх хэлбэр	Модны төрөл	Нарийн үзүүрийн голч, см	Түлшний модны урт, м
1	Уртаар	Шилмүүст ба навчит төрлийн мод	3-14	1,0
2	хэрчим буюу цуулж хагалсан байдлаар	“-“	15-аас дээш	0,25; 0,3; 0,5; 0,75

ТАЙЛБАР 1: 15 см-ээс дээш голчтой хэрчмийг хоёроос дээш хэсэгт хуваан цуулж хагалсан байна.

ТАЙЛБАР 2: Хэрэглэгчийн шаардлагаар дээр заасан хэмжээнээс богино хэмжээтэй бэлтгэн нийлүүлж болно. Энэ тохиолдолд хэлбэлзэл нь 0,05-аас +0,10 хүртэл байна.

6.2 Хэрэглээний шаардлагаас хамаарч түлшний мод нь дараах нэмэлт шаардлагыг хангасан байна.

6.2.1 Түлшний модыг товарлаг чанараар муу, хэрэглээний шаардлага хангаагүй бүх шилмүүст ба навчит төрлийн модноос ой цэвэрлэх зориулалтаар бэлтгэнэ.

6.2.2 Түлшний модны өмхрөөгүй модлогийн эзлэх хувь нягтаар хэмжсэн нэг шоометр багцын эзэлхүүний 80 %-иас доошгүй байвал зохино.

6.2.3 Түлшний модонд бүх төрлийн яр, гэмтэл согог болон цөмийн ба зуламын өмхийг тайрцын талбайн 65 хувьд зөвшөөрнө.

6.2.4 Тайрцын талбайн 30-аас 60 % хүртэлх өмхтэй түлээний тоо хэмжээ нь хүлээн авч байгаа нийт түлээний 20 %-иас хэтэрч болохгүй.

6.2.5 Түлшний модны гадаргууд нунтгарсан өмх байхыг зөвшөөрөхгүй.

6.2.6 Түлшний модны уртын хэмжээнд ± 2 см-ийн хэлбэлзлэл байж болно. Хэрэв энэ хэлбэлзлэлд багтаж байвал уртын хэмжээний доод шатлалд, түлшний модны урт үүнээс дээш хэлбэлзлэлтэй байвал дээд шатлалд хамааруулан тооцно.

6.2.7 Түлшний мод холтостой ба холтосгүй байж болно. Мөчрөөс бүрэн цэвэрлэсэн байна.

6.2.8 Ургаа нойтон мод, түймэр, хортон шавж болон бусад гаднын нөлөөнд өртөж гэмтээд дахин сэргэн ургаж байгаа мод, түүнчлэн өсвөр мод, жодоо, хуш, гацуур, хайлаасыг дээд шатны байгууллагын тусгай зөвшөөрөлгүйгээр түлээнд бэлтгэж хэрэглэхийг хориглоно.

7 Түлшний модыг хүлээн авах

7.1 Түлшний модыг хэсгээр /бөөнөөр/ нь хүлээн авна. Стандартын шаардлагад тохирсоныг баталгаа болгосон баримттай янз бүрийн тоо хэмжээний түлшний модыг нэг багц гэж тооцно.

7.2 Баримт бичигт дараах зүйлийг тусгана. Үүнд:

- Бэлтгэн нийлүүлэгчийн нэр, хаяг
- Модны төрөл
- Тоо хэмжээ

7.3 Түлшний модыг сийрэг шоометр, эзлэхүүнээр хэмжиж хүлээн авна.

8 Түлшний модыг хэмжиж тооцох

8.1 Өрж хураасан түлшний модны тоо хэмжээг /эзэлхүүн/ тодорхойлохдоо түүний өндөр, урт, өргөнийг хэмжин, үржүүлж гаргана.

8.2 Нягтын шоометрийг сийрэгт шилжүүлэхдээ:

- 5 – 24 см голчтой модыг 2,20
- 24 – 36 см голчтой модыг 1,83
- 38 см–ээс дээш голчтой модыг 1,43 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлж тооцно.

9 Түлшний модыг тээвэрлэх

9.1 Түлшний модыг зөвхөн ачааны зориулалтын тээврийн хэрэгслэлээр тээвэрлэх ба тээврийн төрөл бүрт үйлчлэх ачаа тээврийн дүрмийн дагуу ачиж тээвэрлэнэ.

9.2 Төмөр замаар тээвэрлэх тохиолдолд төмөр замын байгууллагаар батлагдсан техникийн нөхцлийн дагуу ачиж тээвэрлэнэ.

ТӨГСӨВ.

ТҮЛШНИЙ МОДНЫ ШИНЭЧИЛСЭН СТАНДАРТЫН ТӨСЛИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Нэг. “Түлшний мод. Техникийн шаардлага” MNS 5413:2004 стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал

Стандартчилал, Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөлийн 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 54 тоот тогтоолоор “Түлшний мод. Техникийн шаардлага MNS 5413:2004” стандартыг баталснаас хойш даруй 6 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд 2005 онд нэг удаа нэмэлт өөрчлөлт оржээ. /Тайлбар: нийслэл хот, аймгуудын төвүүдэд тээвэрлэн борлуулах тохиолдолд түлээний модны уртын хэмжээ 0,5 м-ээс илүүгүй байна гэсэн заалтыг 2,20 м-ээс илүүгүй байна гэж өөрчилсөн/

Энэ стандартын хэрэгжилтийн явц өнгөрсөн 6 жилд тун хангалтгүй байлаа дүгнэж болно. Учир нь гэвэл, түлээний мод нэрээр 2,0-2,20 м-ийн урттай хуурай, шүүдэнги, нойтон мод ба түлээ, хэрэглээний модны алин болох ялгагдахгүй янз бүрийн бөөрөнхий мод төв суурин газрууд, ялангуяа Улаанбаатар хотын төвлөрсөн модны захуудын 150 орчим тооны зүсвэрийн дугуй хөрөөнүүдэд нийлүүлэгдэж, банз материал болон зүсэгдэж зах зээлд борлуулагдаж байна.

Энэ үйл ажиллагааны явцад ойн санд ихээхэн хохирол учирч байгаагаас гадна ургаа нойтон мод, бүр нарс зохих хэмжээгээр сүйтгэдэж байгаа нь нэн харамсмаар. Ойн газрын хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх тасгийн 2010 оны эхний 9 сарын нийслэл хотод илрүүлсэн ойн зөрчилд ойн хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоосон байдалд мониторинг хийж үзэхэд нийт зөрчлийн 60 хувь нь бөөрөнхий мод байв. Үүнээс дүгнэлт хийхэд түлээний мод нэртэй хууль бусаар бэлтгэсэн зүсвэрийн бөөрөнхий модны бэлтгэл, тээвэрлэлт, нийлүүлэлтийн байдал үнэхээр анхаарал татсан, шийдвэрлэх асуудал болсон байна.

Сүүлийн 10 гаруй жилийн туршид байдал ийм байгаа бөгөөд “Мод, модон материалын төрөлжсөн захын үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5162:2002 стандартаар зохицуулах оролдлогыг Ойн газар, МХЕГ, НБХГ, НМХГ, НЦГ болон УМБГазраас хамтарсан буюу дангаараа удаа дараа хийсэн үзлэг, шалгалтын мөрөөр зохион байгуулж байгаа боловч зохиосон ажил, хэрэгжүүлсэн арга хэмжээ нь төдий л үр дүнд хүрэхгүй байгааг анхаарах цаг болжээ. Түлээний модны ойн нөөц ашигласны төлбөр буюу ойн гоожин бага, бэлтгэх, тээвэрлэх ажиллагаа хялбар, худалдан борлуулж байгаа болон худалдан авч байгаа иргэн, байгууллагаддаа аль алинд нь банз, дүнз зөөж борлуулснаас илүү ашиг, унацтай бизнес учраас энэ тал руу түлхүү ажиллаж, сүлжээнд орсон гэж дүгнэхээр байна.

Хоёр. Стандарт боловсруулах шаардлага, үндэслэл

Дээр үүсэж бий болсон нөхцөл байдал, зөрчлийг арилгах, түлээний модны бэлтгэл, хангамжийг тогтвортой байлгах, мод бэлтгэлийн журам, зааврын дагуу гүйцэтгэх зорилгоор түлээний модны стандартыг шинэчлэн боловсруулах шаардлага гарсан болно. Үүнд:

1. MNS 5413:2004 стандартад “түлээний мод” гэсэн **тодорхойлолт** байхгүй, **техникийн шаардлага** нь бүдэг, тодорхой бус зэрэг дутагдал байснаас бөөрөнхий

модыг түлээний мод мөн, биш эсэхийг тодорхойлоход хүндрэлтэй тал байсныг ойн зөрчил гаргагчид ашиглаж байсан учир;

2. Түлээний модны уртын хэмжээ 2,20 м-ээс ихгүй байна гэсэн заалт нь дугуй хөрөөний зүсвэрийн мод зөөгчдөд түлээний мод нэрээр тээвэрлэхэд боломж олгож улам өөгшүүлж байсан;

3. Дээрх хэмжээ нь машины тэвшний хэмжээнд зориулагдсанаас ойд ачилтын талбайд түүнд тааруулан тайрч байгаагаас модны бараг 40-60 % нь хаягддаг;

4. Зах зээлд зүсвэрийн түүхий эд маягаар борлуулахаа боддог тул өмх, хорхойн нүх ихтэй, зүсэх боломжгүй торц, нарийн үзүүр, шаталт ихтэй модыг авдаггүйгээс мөн их хэмжээний мод ойд үлдэж дахин түймэр гарах, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэх нөхцөлийг бүрдүүлдэг;

5. Олон улсад түлшний модыг гранул, пеллет, брикет хэлбэрээр нийлүүлдэг бөгөөд зөвхөн тусгай захиалгаар тайрдас, хагалсан мод байдлаар нийлүүлж байна. Манай хөрш ОХУ-д одоо мөрдөгдөж байгаа түлээний модны стандартад уртыг 1,0 м-ээр хязгаарласан байна. БНХАУ-д мод бэлтгэж байгаа байгууллагууд хагалж цуулсан байдлаар багцалж зах зээлд нийлүүлдэг зэргийг харгалзаж;

6. Шинээр батлагдсан ойн сангийн нэг шоометр модны экологи-эдийн засгийн үнэлгээнд бүх төрлийн хэрэглээний хуурай модыг нэмж оруулж өгсөн нь хэрэгцээний болон түлээний модыг ялгавар заагтай, тодорхой болгож өгсөн;

7. Ойн зөрчлийн дийлэнх зөрчил нь бөөрөнхий модон дээр гарч байгааг харгалзаж үзсэн;

8. Түлээний стандартын дагуу бэлтгэсэн боловч хэрэглээнд ашиглаж болох модыг зүссэний төлөө хүмүүст хуулийн дагуу шийтгэл ногдуулж байгаа нь иргэдийг хэлмэгдүүлэх, авилга, хээл хахуулийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болдог;

9. Түлээ гэж төлбөр төлөөд хэрэглээний модны үнээр зах зээлд борлуулж байгаа нь орон нутгийн ойгоос орох орлогод сөргөөр нөлөөлдөг;

Ойн үндсэн ашиглалтын түүвэрлэх болон аажим огтлолт явуулахыг Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор хориглосон шийдвэр гарсан. Манай орны ойд арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоор мод бэлтгэлийн ажлыг явуулах болж, эндээс улс орны хэрэгцээг хангах шинэ зорилт, шаардлага ойн салбарын ажилтан, ажиллагсадын өмнө тавигдаж байна

Үүнтэй уялдан төрөл бүрийн диаметр ба уртын хэмжээтэй түлээний мод их гарах бөгөөд үүнийг ашиглах боломжтойг харгалзан үзсэн зэрэг болно.

Гурав. Шинэчилсэн стандартыг мөрдүүлснээс гарах үр дүн

Түлээний модыг 1,0 м хүртэлх урттайгаар буюу хэрчимлэсэн, хагалж шуудайлсан байдлаар зах зээлд нийлүүлэхэд бэлтгэн нийлүүлэгчид илүү хүндрэл учрахгүй бөгөөд хэдэн хэдэн давуу талтай юм. Үүнд:

1.Өнөөгийн нөхцөлд мод бэлтгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг газрууд сортиментоор ихэвчлэн тээвэрлэж байгаа тул модны үзүүр, ёзоорыг ихэвчлэн ойд овоолж орхиж байгаа ба 2011 оноос арчилгаа, цэвэрлэгээгээр улс орны хэрэгцээг

MNS 5413 : 2011

хангахтай холбогдуулан төрөл бүрийн голч, урттай хаягдал модны хэмжээ улам ихээр нэмэгдэх учир эдгээрээс түлээний модны нийлүүлэлт нэмэгдэнэ.

2.Ой хамгаалах чиглэлээр байгуулагдан ажиллаж байгаа ойн нөхөрлөлүүдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, хүсэл сонирхлыг дээшлүүлэхэд өөрийн эзэмшлийн ойгоос ойн цэвэрлэгээгээр түлээний мод бэлтгэж тухайн сумынхаа хэрэгцээг хангахад ач холбогдолтой арга хэмжээ болно.

3.Түлээний модыг жижиглэсэн байдлаар нийлүүлэх нь ой цэвэрлэгээний ажилд ахиц дэвшил гарахын зэрэгцээ модыг бүрэн, хаягдалгүй ашиглах, автомашины даац ашиглалтыг нэмэгдүүлэх зэрэг ач тустай.

4.Төмөр замын дагуух Сэлэнгэ, Орхон, Төв аймгийн зарим иргэн, байгууллага түлээний модыг хэрчимлэсэн, хагалж шуудайлсан байдлаар вагонаар тээвэрлэж нийслэл хотод нийлүүлж байна. Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн Биологийн төрөл зүйлийг хамгаалах төсөл Мандал сумын ойн нөхөрлөлүүдийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж, шуудайлсан мод бэлтгүүлж Улаанбаатарт ачуулж байна. Иймд үүнийг албан ёсоор стандаржуулах шаардлага гарч ирж байгаа юм.

5.Шинэчилсэн стандарт батлагдан гарч мөрдөгдсөнөөр улсын хэмжээнд түлээний модыг тээвэрлэж зах зээлд нийлүүлэхэд нэг мөр ойлголттой болж, нэгдсэн хяналтын систем тогтож, гардаг зөрчлийн асуудал бүр мөсөн шийдвэрлэгдэнэ.

Тайлбар: Энэхүү стандартын төслийг боловсруулахад БОАЖЯ, УМХЕГ, НБХГ, НМХГ зэрэг байгууллагуудын урьдчилсан саналыг тусгаж, Ойн газрын даргын зөвлөлийн хурал, “Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх нь” сэдэвт улсын зөвөлгөөнөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн болно.

ОЙН ГАЗРЫН ОЙН АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ ХЭЛТЭС